

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Япон Улсын Засгийн газрын “Өвсний Үндэс” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх Чингэлтэй дүүргийн 103 дугаар цэцэрлэгийн их засварын ажил

Тендер шалгаруулалтын дугаар: ЧДХААА А19/002

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Чингэлтэй дүүргийн 103 дугаар цэцэрлэгийн их засварын ажил”-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг 100.000 (нэг зуун мянган) төгрөгөөр худалдан авч болно.

Төлбөрийг Чингэлтэй дүүрэг худалдан авах ажиллагааны албаны Төрийн сан банкин дахь: 100200751009 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2017, 2018/-ийн дундаж нь 140 000 000 /нэг зуун дөчин сая/ төгрөгөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 60 000 000 /жаран сая/ төгрөгөөс багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018 он/

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жил /2017, 2018/-ны аль нэгэнд ядаж нэг удаа 140 000 000 /нэг зуун дөчин сая/ төгрөгөөс багагүй үнэтэй барилгын засварын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

Шаардлагатай тусгай зөвшөөрөл Барилга хот байгуулалтын яамнаас олгосон:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

Эсхүл Барилга хот байгуулалтын яамнаас олгож байгаа шинэ журмын

- БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт.

- БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил.

Тендерийн хамт 4 000 000 /дөрвөн сая/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр. Худалдан авах ажиллагааны алба  
511 тоот өрөө Утас : 70110769